



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 128

Номгон

Г Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Соёрхол тэмдэг, Хүндэтгэл
шагналаар шагнах тухай


Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал, түүнийг олгох журам”-ын 3.6 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хүүхдийн “Тэмүжин” театр байгуулагданы 30 жилийн ойг тохиолдуулан тус театрын ахмад багш П.Өлзийбаяр, анхны багш Г.Ганбаатар нарыг “Соёрхол” тэмдгээр, мөн тус театрын анхны багш Д.Баттөмөр, Япон хэл, математикийн гүнзгийрүүлсэн, дүрслэх урлахуй, дуу хөгжмийн мэргэжлийн сургалттай бүрэн дунд сургуулийн нярав С.Болдбаатар нарыг “Хүндэтгэл” шагналаар тус тус шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах 10000 /далан мянган/ төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР





БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 129

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Соёрхол тэмдэг, Хүндэтгэл
шагналаар шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал, түүнийг олгох журам”-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны өдрийг тохиолдуулан бүртгэлийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй Бямбаагийн Хүрэлчuluун, Базардараагийн Тунгалаг, Лхамсүрэнгийн Бүрнээбаатар нарыг “Соёрхол” тэмдгээр, Рэгсүрэнгийн Насанжаргалыг Хүндэтгэл шагналаар тус тус шансуягай.

2. Шагналд зарцуулагдах 85000 /наян таван мянган/ төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

